



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/284

Хэрлэн сум

Нөөцийн махны урамшуулалд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3 дахь заалт, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол 2023 оны 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын улиралд үүсэж болзошгүй махны хомсдол, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөцийн махыг борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох 5/37 дугаартай гэрээний дагуу хэрэгжилт хангагдсан тул 80,000,000 (наян сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Зарцуулах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг 2023 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 05-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Нөөцийн махны урамшуулалд
зарцуулах хөрөнгийн тооцоо

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ /тн/	Нэгж урамшууллын үнэ /₮/	Нийт урамшууллын үнэ /₮/	Урьдчилгаа 30%	Үлдэгдэл 70%
1	Хонины мах	40	1000	40,000,000	5 сард	
2	Үхрийн мах	20	2000	40,000,000		6 сард
	Нийт			80,000,000	24,000,000	56,000,000